

СОЁЛ, УРЛАГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА УР ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Мягмарсүрэнгийн Амартүвшин^{1,*}
Жүгдэрнамжилын Эрхэмтөгс^{2,*}
Нямдоржийн Туул³

¹ Соёл урлагийн их сургуулийн Сургалт, цахим шилжилтийн газар, Улаанбаатар, Монгол улс ORCID: 0009-0009-4329-9341

² Доктор (Ph.D), профессор, Соёл урлагийн их сургуулийн Хөгжлийн хорооны дарга, Улаанбаатар, Монгол улс ORCID: 0000-0003-2832-0391

³ Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол улс ORCID: 0009-0009-6797-3492

* Холбоо барих зохиогчид: erhemtugs@gmail.com

amartuvshin@mnuac.edu.mn

Хураангуй: Соёл, урлагийн салбарт соёлын ажилтан бэлтгэж байгаа их, дээд сургуулиуд 2014 оноос хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлж, мэргэжлээс хөтөлбөрт шилжин, боловсролын зорилго, зорилтоо дэлхий дахины соёл, урлагийн салбарын хөгжлийн чиг хандлагатай уялдуулах ажлуудыг хийж ирсэн байна. Шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөрүүдийг үр дүнд чиглэсэн байхыг чухалчилж, хөтөлбөрөөр суралцаж, төгсөгчдөд хөрвөх чадварыг нэмэгдүүлэх мэдлэг, ур чадвар, хандлагыг цогцоор нь хөгжүүлэх асуудлыг тусган, хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн шинэчлэлийн үр дүнг үнэлэх соёл, урлагийн хөдөлмөр эрхлэлт ба ур чадварын нийцлийг тодорхойлох зорилгоор Соёл урлагийн их сургуулийн жишээн дээр 2022 оноос өмнө (2016-2022 он) хугацаанд төгссөн 6 чиглэлийн 519 төгсөгчдийг судалгаанд хамруулан түүврийн аргаар социологийн судалгааг хийлээ.

Өнөөгийн сургалтын байгууллага нь ажил олгогч, хөдөлмөрийн зах зээл, оролцогч талуудтай нягт хамтран ажиллах, өнөөгийн болоод ирээдүйн эрэлт хэрэгцээнд нийцсэн дээд боловсролтой соёлын ажилтныг бэлтгэх түүнд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгох, тасралтгүй сайжруулах, шинэчлэх үнэлэх хэрэгцээ шаардлага байгааг тус судалгаа, шинжилгээний үр дүн харуулж байна.

Түлхүүр үгс: соёл, урлагийн хөдөлмөр эрхлэлт, ур чадвар, ажлын байрны нийцэл

EMPLOYMENT IN THE CULTURAL AND ARTS SECTORS AND SOME RESULTS OF THE SKILL RESEARCH

Amartuvshin Myagmarsuren^{1,*},
Erkhemtugs Jugdernamjil^{2,*},
Tuul Nyamdorj³

¹ Department of Academic Affairs and Digitalization, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia ORCID: 0009-0009-4329-9341

² Doctor (Ph.D), Professor, Development Committee of Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia ORCID: 0000-0003-2832-0391

³ School of Culture, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia ORCID: 0009-0009-6797-3492

* Corresponding authors: erhemtugs@gmail.com

amartuvshin@mnuac.edu.mn

Abstract: Since 2014, the universities and colleges which provide cultural workers and artists in the fields of culture and arts have been implementing curriculum reforms, moving from specialty-based to program-based ones, and been carrying out new and updating tasks to align their educational goals and objectives with the development trends of the global culture and arts sector. The reformed curriculums focus on being outcome-based, reflecting and implementing comprehensive development of knowledge, skills, and attitudes to increase the transferability of graduates through the curriculum. In order to evaluate the results of the reform of the curriculum and to determine the compatibility between employment in the cultural and arts sectors and the skills, a sociological survey was conducted based on sampling method on 519 graduates of 6 fields who graduated before 2022 (2016-2022) on the the Mongolian National University of Arts and Culture.

The research and analysis show that today's educational institutions need to closely cooperate with employers, the labor market, and stakeholders, to prepare highly educated specialists and artists that meet current and future demands, to create, continuously improve, and update the curriculum aimed at them.

Keywords: *culture and arts employment, skills, job matching*

Оршил


Дэлхийн улс орнуудад даяаршил, техникийн дэвшлээс улбаалан нийгэм, эдийн засгийн хүрээнд шинэ чиг хандлагууд бий болж байгаа нь бидний өдөр тутмын ажил, амьдралд хүчтэй нөлөө үзүүлж, хувьсан өөрчлөгдөж байна. Энэхүү нөлөө нь уламжлалт ажлын байрны ойлголт, хэв маягийг өөрчлөгдөхөд хүргэхийн сацуу соёлын ажилтнууд хил хязгааргүй шилжин ажиллах, бүтээн туурвих шинэ боломжууд бүрдэж, олон соёлын орчинд ажиллах, зайнаас буюу цахимаар ажиллах, хэд, хэдэн ажлын байранд зэрэг ажиллах зэрэг хэрэгцээ шаардлага хэдийнээ бий болжээ. Хөдөлмөрийн зах зээлийн энэхүү өөрчлөлт, хөгжлийн шинэ хандлага нь боловсролыг ажлын байртай улам бүр нягт уялдуулах, сургалт, судалгаа, уран бүтээлээр дамжуулан нийгэм соёлын инновацыг бүтээх, боловсролын өгөөж,

капитал хөрөнгө үр ашгийг нэмэгдүүлэх, хамаарал, нийцлийг хангах зэрэг шаардлагууд бий болсныг улам тодотгох болжээ. Америкийн нэрт эдийн засагч, эрдэмтэн Теодор Шульц “Боловсролоор бүтээгдсэн капитал” хэмээх бүтээлдээ (1960) “Боловсрол нь хүнийг хөдөлмөрийн зах зээл дээрх үнэ цэнтэй капитал мөн бөгөөд боловсролын хөрөнгө оруулалт нь хамгийн үр ашигтай хөрөнгө оруулалт” хэмээн үзсэн бол судлаач Д.Бадарч боловсрол нь түүнийг эзэмшсэн хүний салшгүй нэг хэсэг тул хүмүүн капитал (Бадарч, 2021, 3) гэжээ. Харин Г.Беккер нь мэдлэг, ур чадвар нь хөдөлмөрийн бүтээмжийг өсөхөд чухал үүрэгтэй капитал гэсэн зэргээс мэдлэгийн эдийн засгийн хүрээнд компани өрсөлдөх чадвар, тогтвортой ажиллах байдал нь хүний нөөцөөс ихээхэн хамаарах болсныг харуулж байна. Иймээс өнөөгийн ажил олгогчид хүний нөөцийг тухайн ажлын байранд гүйцэтгэх ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадвартай байхын сацуу хувь хүний хувьд төлөвшсөн, инновацыг хэрэгжүүлэх бүтээлч хандлагатай байхад чухалчлах болсон.

Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд мэргэжлээс хөтөлбөрт шилжих сургалтыг хөтөлбөрт суурилсан байдлаар явуулах ажлын эхлэлийг БШУ-ны Сайдын 2014 оны А/160 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд соёл, урлагийн чиглэлийн (бакалаврын, магистрын, докторын) 55 хөтөлбөрийн (давхардалгүй) нэр, индекс батлагдаж, хөтөлбөрийн шинэчлэлийг их, дээд сургуулиуд эрчимтэй хэрэгжүүлж ирсэн билээ. Соёл, урлагийн сургалт нь ажлын байрны эрэлт, чиг хандлагатай нийцүүлэх нь ажил олгогч төгсөгчдийн хоорондын нийцэл, ур чадварын зөрүүг арилгах зорилгоор үр дүнг чухалчлах, ажлын байртай нягт уялдуулах ажлуудыг хийж иржээ. Соёл, урлагийн салбарын соёлын ажилтан нь өнөөгийн дэлхийн нийтийн чиг хандлагатай нягт уялдан хөгжих, хувьсах, олон соёлын өрчинд ажиллах, бүтээн туурвих өөрийн орны үндэсний өвөрмөц сэтгэлгээ, онцлог, соёлын ялгаатай байдлаа хадгалах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний бахархал, эв нэгдлийг бэхжүүлэх, “Монгол” хүнийг хөгжүүлэх зэрэгт чухал үүрэгтэй билээ. Иймд соёл урлагийн хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ “Үр дүнд суурилсан боловсрол” нь суралцагчид мэдлэг, чадвар, хандлага олж авахын төлөөх тэдний суралцах үйл ажиллагааг дэмжих тасралтгүй үйл явц (Ж.Эрхэмтөгс, 2020, 152) гэжээ. Уг хөтөлбөрийн шинэчлэлийн хийгдсэн сургалтын хөтөлбөрийн чанар, нийцлийг судлах зорилгоор Соёл урлагийн их сургуулийг сонгон авч 2022 оноос өмнө (2016-2022 онд) төгссөн төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлага болон хөрвөх чадварын төгсөгчдийн өөрийн үнэлгээг тодруулах зорилгоор доорх судалгааг хийв.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг манай улсын соёл, урлагийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөрийн эрхлэлтийн өнөөгийн байдлыг тодорхойлохдоо “Мэдлэг – Чадвар (мэргэжлийн) – Хандлага – Хөрвөх чадвар” гэсэн тулгуур зарчим бүхий арга зүйн загвар (*Зураг 1*)-ыг баримталж, судалгаа боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн.



Хөдөлмөр эрхлэлтийн чиг хандлага, ажлын байрны эрэлт хэрэгцээ

Зураг 1. Хөдөлмөрийн зах зээл ба ур чадвар

Соёл, урлагийн мэргэжлээр төгсөгчдийн “мэдлэг – чадвар – хандлага – хөрвөх чадвар”-ыг Лайкертын шкалаар (1=хангалтгүй, 2=тааруу, 3=дунд зэрэг, 4=сайн, 5=хангалттай сайн) үнэлж, түүвэр судалгааны аргаар мэдээлэл цуглуулсан (түүврийн илтгэх түвшин 95%, алдааны хязгаар 5% байхаар тооцсон).

Судалгааны асуулгын найдвартай байдлыг туршилт судалгаагаар шалгахад, ач холбогдол нь өндөр гарсан тул уг асуулгын дагуу судалгааны өгөгдлийг цуглуулсан. Энэхүү судалгааны өгөгдөлд найдвартай байдлын шинжилгээ хийхэд Кронбах альфа коэффициент дундаж үзүүлэлт 0.920, судалгааны түүвэр нь эх олонлогоо төлөөлөх чадварыг шалгахад КМО коэффициент 0.945 буюу ач холбогдолтой гарсан нь энэхүү судалгааны асуулга ойлгомжтой, түүврийн хэмжээ хүрэлцээтэй, түүвэр нь эх олонлогоо төлөөлж чадаж байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчид

Манай улсад 2023 оны байдлаар соёл, урлаг, нийгмийн ухааны чиглэлд хамаарах сургалтын хөтөлбөрөөр нийт 6 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Үүнд “Соёл урлагийн их сургууль”, “Монгол улсын консерватор”, “МУБИС-ийн Дүрслэх урлаг, технологийн сургууль”, “Кино урлагийн дээд сургууль”, “Сити их сургууль”, “ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн, технологийн дээд сургууль”-д нийт 124 сургалтын хөтөлбөр (давхардсан тоо) хэрэгжиж байгаагаас бакалаврын түвшинд 3864 оюутан суралцаж байна. Соёл урлагийн их сургуульд дангаараа нийт суралцагчдын 60% нь буюу 2323 оюутан суралцаж байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчид он, эзлэх хувиар

Он	Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоо	Бүжгийн урлаг	Дүрслэх урлаг	Радио, телевиз, медиа урлаг	Соёл	Театрын урлаг	Хөгжмийн урлаг
2016	74	5.4	8.1	39.2	14.9	13.5	18.9
2017	47	2.1	6.4	38.3	23.4	12.8	17.0
2018	43	9.3	4.7	20.9	16.3	11.6	37.2

2019	45	4.4	2.2	20.0	24.4	15.6	33.3
2020	78	12.8	15.4	11.5	14.1	19.2	26.9
2021	90	11.1	18.9	14.4	20.0	21.1	14.4
2022	142	8.5	12.7	24.6	31.7	13.4	9.2
	519	8.3	11.4	23.5	22.0	15.6	19.3

Судалгаанд соёл, урлагийн дээд боловсролын сургалтын байгууллагыг 2016-2022 онд төгссөн 519 төгсөгчдийг хамруулсан. Нийт судалгаанд оролцогчдын 66.3% нь эмэгтэй, 33.7% нь эрэгтэй төгсөгч хамрагдсан байна.

Соёл, урлагийн хөдөлмөр эрхлэлт ба ур чадварын үнэлгээ

Энэхүү судалгаа, боловсруулалтын ажлаар соёл, урлагийн дээд боловсролтой мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг мэргэжлийн чиглэлээр судлан тодруулж дүн шинжилгээ хийж, үр дүнг доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар

№	Мэргэжлийн чиглэл	Мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэлт		Сургууль төгсөөд орсон анхны ажлаа сольсон байдал	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Бүжгийн урлаг	74.4	25.6	37.2	62.8
2	Хөгжмийн урлаг	62.0	38.0	40.0	60.0
3	Соёлын	72.8	27.2	39.5	60.5
4	Театрын урлаг	71.6	28.4	50.6	49.4
5	Радио, телевиз, медиа урлаг	70.5	29.5	52.5	47.5
6	Дүрслэх урлаг	62.7	37.3	55.9	44.1
	Дундаж үзүүлэлт	69.0	31.0	45.9	54.1

Дээрх хүснэгтээс төгсөгчдийн 69% нь төгссөн мэргэжлээрээ ажилласан бол 31% нь ажлаа сольсон байна. Сургуулиа төгсөөд анхны ажлаа 45.9% нь сольсон бол 54.1% нь үргэлжлүүлэн ажиллаж байгаа гэсэн хариулт өгчээ. Ажлаа сольсон шалтгааныг нарийвчлан тодруулан авч үзэхэд, 22.8% нь ажлын ачаалал, ажлын орчин, цалин хангамж хангалтгүй, 19.9% нь өөр ажилд орох болсон, 11.5% үргэлжлүүлэн суралцах болсон, эмэгтэй төгсөгчдийн дунд 9.6% хүүхэд асрах, жирэмсний болон амаржсаны чөлөө авах шалтгаанаар, 7.1% нь нүүдэл, шилжилт хөдөлгөөний улмаас гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Хүснэгт 3. Төгсөгчдийн “Мэдлэг”-ийн түвшний үнэлгээ

№	Үзүүлэлт	Театрын урлаг	Бүжгийн урлаг	Соёл	Хөгжмийн урлаг	Радио, телевиз, медиа урлаг	Дүрслэх урлаг	Дундаж
1	Мэргэжлийн суурь мэдлэг	3.99	3.98	3.79	4.01	3.85	3.76	3.89

2	Мэргэжлийн нарийн мэдлэг	3.95	3.91	3.70	4.05	3.71	3.57	3.81
3	Онолын мэдлэг	3.77	3.79	3.91	3.61	3.83	3.54	3.76
4	Гадаад хэлний мэдлэг	2.77	3.23	3.30	2.98	2.90	2.48	2.96
Дундаж үзүүлэлт		3.62	3.73	3.68	3.66	3.57	3.34	3.61

Дээрх хүснэгтээс харвал, төгсөгчдийн мэдлэг олгосон түвшний хувьд судалгаанд оролцогчдын дунджаар хамгийн өндөр буюу 3.89 (сайн) гэсэн үнэлгээг “Мэргэжлийн суурь мэдлэг” олгох дээр өгсөн бол дунджаар хамгийн бага үнэлгээг буюу 2.96 (тааруу) гэсэн үнэлгээг “Гадаад хэлний мэдлэг”-ийн түвшин гэсэнд өгсөн байна. Иймд гадаад хэлний сургалтыг сайжруулах сургалтын хөтөлбөр дэх англи хэлний практик хэрэглээг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд анхаарах шаардлагатай байна.

Хүснэгт 4. Төгсөгчдийн “Мэргэжлийн ур чадвар”-ын түвшний үнэлгээ

№	Үзүүлэлт	Театрын урлаг	Бүжгийн урлаг	Соёл	Хөгжмийн урлаг	Радио, телевиз, медиа урлаг	Дүрслэх урлаг	Дундаж
1	Бие даан ажиллах чадвар	4.20	4.14	4.01	4.03	4.02	4.14	4.07
2	Ажил мэргэжлийн ур чадвар	4.07	3.89	3.82	4.03	3.80	3.73	3.89
3	Турших, судлах чадвар	3.81	3.91	3.71	3.69	3.74	3.56	3.73
4	Системтэй сэтгэх чадвар	3.73	3.68	3.62	3.57	3.57	3.28	3.58
5	Баримт бичиг боловсруулах	3.13	3.56	3.70	3.23	3.25	2.46	3.26
Дундаж үзүүлэлт		3.79	3.83	3.77	3.71	3.67	3.43	3.71

Дээрх хүснэгтээс харвал төгсөгчдийн “Бие даан ажиллах чадвар”-т хамгийн өндөр үнэлгээг 4.07 (хангалттай) өгсөн байна. Харин “Баримт бичиг боловсруулах ур чадвар”-т хамгийн бага буюу 3.26 (дунд зэрэг) үнэлгээ өгсөн байна. Мэргэжлийн ур чадварын түвшний үнэлгээ нь дунджаар 3.71 (дунд зэрэг) байгааг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 5. Төгсөгчдийн “Хандалага”-ын түвшний үнэлгээ

№	Үзүүлэлт	Театрын урлаг	Бүжгийн урлаг	Соёл	Хөгжмийн урлаг	Радио, телевиз, медиа урлаг	Дүрслэх урлаг	Дундаж
1	Багаар ажиллах ур чадвар	4.27	4.05	3.98	4.00	3.98	3.46	3.98
2	Харилцааны ур чадвар	4.25	3.82	4.05	4.11	3.90	3.35	3.96

3	Ёс суртахууны төлөвшил	4.05	3.83	3.99	3.95	3.92	3.56	3.91
4	Хувь хүний манлайлал	4.05	3.84	3.96	3.86	3.67	3.42	3.81
5	Цаг төлөвлөх	3.81	4.00	3.93	3.90	3.66	3.05	3.75
6	Асуудал шийдвэрлэх чадвар	3.84	3.72	3.75	3.65	3.64	3.39	3.68
Дундаж үзүүлэлт		4.05	3.88	3.94	3.91	3.79	3.37	3.85

Дээрх хүснэгтээс харвал төгсөгчдийн зүгээс мэргэжлийн ур чадвараас гадна багаар ажиллах, харилцааны зэрэг хувь хүний төлөвшилд чиглэсэн үзүүлэлт буюу “Багаар ажиллах ур чадвар”-ыг хамгийн өндөр буюу дунджаар 3.98 оноог гэж дүгнэсэн бол “Асуудал шийдвэрлэх чадвар”-ыг 3.68 буюу дунджаар хамгийн багаар үнэлсэн байна.

Хүснэгт 6. Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дээрх “Хөрвөх чадвар”-ын үнэлгээ


№	Үзүүлэлт	Театрын урлаг	Бүжгийн урлаг	Соёл	Хөгжмийн урлаг	Радио, телевиз, медиа урлаг	Дүрслэх урлаг	Дундаж
1	“Сэтгэх” чадвар	4.21	4.03	3.87	3.90	4.00	4.07	3.99
2	“Зохиох” чадвар	4.16	3.93	3.89	3.68	3.94	4.09	3.93
3	“Бүтээх” чадвар	4.16	4.03	3.93	3.78	3.91	4.10	3.96
4	“Хэрэглэх” чадвар	3.97	4.09	3.87	3.74	3.74	3.81	3.84
Дундаж үзүүлэлт		4.12	4.02	3.89	3.78	3.89	4.02	3.93

Дээрх хүснэгтээс харвал төгсөгчдийн зүгээс ажлын байран дээр хөрвөх ур чадвар эзэмшсэн байдлыг бусад судалгаанд орсон асуулгуудаас хамгийн өндрөөр үнэлсэн байна. Хамгийн өндрөөр “сэтгэх чадвар” 3.99 үнэлгээг өгсөн бол хамгийн бага үнэлгээг “хэрэглэх” гэж тус тус дүгнэжээ. Энэ нь цаашид хэрэглэх чадварыг сайжруулах, ажлын байранд суурилсан сургалт, дадлагыг үр дүнтэй зохион байгуулах, хэрэглэх чадвар, чадамжийг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хэлэлцүүлэг

Тус судалгааны хүрээнд ажлын байрны эрэлт, хэрэгцээ нийгмийн шаардлагыг судалж, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн шинэчлэлээр хийгдсэн “Мэдлэг-чадвар-хандлага-хөрвөх чадвар”-ыг үнэлж, суралцахуйн үр дүнгийн өнөөгийн түвшнийг тодорхойлохыг зорилоо.

Уг судалгааны боловсруулалтын үр дүнд төгсөгчдийн өөрийн үнэлгээг театрын урлагийн чиглэлээр төгсөгчид хамгийн өндөр дундаж үзүүлэлтээр 3.9 гэж өгсөн бол харин хамгийн бага үнэлгээг дүрслэх урлагийн чиглэлээр төгсөгчид дундаж үзүүлэлтээр 3.5 гэсэн үнэлгээг өгсөн байна. Төгсөгчдийн ур чадварын ерөнхий үнэлгээний дундаж үзүүлэлтийг авч үзвэл, хамгийн бага үнэлгээг “мэдлэгийн ур чадвар” 3.6 дунд зэрэг олгосон гэсэн үнэлгээг өгсөн бол хамгийн өндөр үнэлгээг “хөрвөх чадвар”-ыг 4.0 сайн олгосон гэж үнэлжээ.



Зураг 2. Төгсөгчдийн ур чадварын ерөнхий үнэлгээний харьцуулалт

Мэргэжлээс хөтөлбөрт шилжсэнээр сургалтын хөтөлбөрийг үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу боловсруулж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд, мэргэжлийн онцлогт нийцэх суралцахуйн үр дүнгүүд нь нийлмэл буюу мэдлэг, чадвар, хандлагаас тогтох “сэтгэх, зохиох, бүтээх, хэрэглэх” зэрэг нь үр дүнтэй байгаа хэдий ч цаашид шинээр бий болж байгаа технологийн хөгжилтэй уялдуулан дээрх ур чадваруудыг жигд олгох асуудлыг чухалчлах шаардлагатай гэж үзэж байна.

ОХУ-ын “SKOLKOVO” болон “Atlas Of Emerging Jobs” зэрэг байгууллагууд 2017 онд олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), “BRICS Business Council”-тай хамтран дэлхийн 77 оронд явуулсан “Global Education Future”-ын судалгаагаар “21-р зууны ажлын байр, ур чадварыг тодорхойлох тренд”-үүд “Хүн ам зүйн өөрчлөлт” (Demographic changes), “Сүлжээний нийгэм” (Network society) буюу сошиал орчин, “Даяаршил”, “Дижиталчлал” (Digitalization) буюу технологийн дэвшил зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий хүрээнд гарч буй шинэ, чиг хандлага өөрчлөлтөөс улбаалан ажлын байрны хэв шинж, түүнд шаардлагатай ур чадвар хүний хөгжлийн асуудал ажлын байрны ур чадварт шууд хүчтэй нөлөө үзүүлж байна гэж дүгнэлтийг хийжээ (“Skills of the future: How to thrive in the complex new world,” 2017).

Иймээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлт – нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах асуудал нь мэргэшлийн хүрээнд суурилсан дээд боловсрол – ирээдүйн ажлын байрны уялдааг хангах тогтолцоог оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлан хөгжүүлэх юм. Угтаа дээд боловсрол – ирээдүйн ажлын байрны уялдааг хангах нь хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд “мэдлэг – чадвар – хандлага – хөрвөх чадвар”-ын хувьд хир нийцтэй байгаа эсэх тухай асуудал билээ.

Олон улсын эдийн засгийн форумас явуулдаг хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагын судалгааны тайланд 2025 он гэхэд шаардлагатай болох ур чадварын жагсаалтад “Асуудал шийдвэрлэх”, “Хувийн зохион байгуулалт”, “Бусадтай хамтран ажиллах”, “Технологи ашиглах ур чадвар” зэргийг хамгийн чухалд тооцож, технологийн хөгжлийг дагасан ур чадваруудыг онцолсон байна (“The Future Jobs,” 2020).

Өнөөгийн төгсөгчдийн чанар нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцэж байна уу, 21-р зуунд ажиллах соёл урлагийн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын технологи, стандарт ямар байх бэ?

Монголын соёл урлагийн салбарт хэчнээн тооны ямар мэргэжлийн хэдэн хүн, ямар хугацаанд хэрэгтэй болох вэ? гэдгийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан тогтоох шаардлагатай байна.

Дүгнэлт, санал

Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ “мэдлэг, ур чадвар, хандлага”-ын хослолыг бий болгоход суралцахуйн, багшлахуйн нарийн систем-тогтолцоонд тулгуурлах, соёл урлагийн салбарын бодлого, стратегитай уялдуулан хүний нөөцийн ирээдүйн төлөв, соёлын ажилтныг бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх арга зүй загварчлалыг уялдуулан тодорхойлох шаардлагатай байна. Ингэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

- Их, дээд сургууль нь ажил олгогч, хөдөлмөрийн зах зээл, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, (төгсөгч, ажил олгогч, сургууль) хамтын ажиллагааны тодорхой механизмуудыг бүрдүүлэх, давтан сургах-мэргэшүүлэх
- Ирээдүйд шаардлагатай болж байгаа ур чадварыг олгох асуудлыг “Ажлын байранд суурилсан сургалт”-ын хэлбэрээр зохион байгуулах, түүнд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгох. Бакалаврын нэг хөтөлбөрт 20 хүртэл багц цагаар бий болгох
- Технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдан зарим хэрэглээний ур чадварт өөрчлөлт орж байгааг харгалзан үзэж, технологийн хэрэглээний ур чадварыг тасралтгүй сайжруулах, сургалтаар технологийн хэрэглээг нэмэгдүүлэх
- Хиймэл оюун ухааны тусламжтайгаар хөгжим зохиох, зураг зурах, уран бүтээл туурвих “VR”, “AR” зэрэг технологийн шинэ сорилттой соёлын ажилтанд тулгарч байгаа асуудлыг хэрэглээ, харилцааг зохицуулах асуудлыг хөтөлбөрийн шинэчлэлд тусгах, холбогдох ур чадварыг олгоход анхаарах шаардлагатай байна.

Аж үйлдвэрийн IV хувьсгал, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийн нөлөө нь өнөөгийн сургалтын хөтөлбөрийг эргэн харах үнэлгээ, дүгнэлт өгөх, тасралтгүй сайжруулах, давтан сургах-мэргэшгүүлэх салбарын мэргэшлийн шаталсан бүтэц, тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Бадарч, Д. 2021. *Дээд боловсролын онол, арга зүй: Парадигмийн шилжилт, багшлахуй, суралцахуй*. Улаанбаатар, Монгол Улс: ШУТИС-ийн хэвлэх үйлдвэр.
2. Орхон, Г. 2018. “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн тухай ойлголтыг тодруулах нь.” *Дээд боловсрол*, 01: 173-186.
3. Жилээ, Ж., Тамир, Х., Дэлгэржав, М., 2020. *Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар, Монгол Улс: Соёмбо принтинг.
4. Эрдэнэхүү, Н., ба бус. 2017. *Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж*. Улаанбаатар, Монгол Улс.
5. Эрхэмтөгс, Ж., Тогтох, Ж., Баярмаа Б. 2020. *Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ*. Улаанбаатар, Монгол Улс.
6. Sneed, O. “Integrating Technology with Bloom’s Taxonomy.” 2023.01.09. <https://teachonline.asu.edu/>. 2023.06.10. <https://teachonline.asu.edu/2016/05/integrating-technology-blooms-taxonomy/>.
7. World Economic Forum. 2020. “The Future Jobs report.” https://www3.weforum.org/docs/WEF_Future_of_Jobs_2020.pdf?_gl=1*x51qpo*_up*MQ..&gclid=Cj0KCQiA4NWrBhD-ARIsAFCKwWsgIz10S-6nSIIqEGyuJIT-i3n1ojpIvuwkUFcaIVSBGe_paOZZrkMaApgkEALw_wcB. 2023.10.23.
8. Global Education Futures., WorldSkills Russia. 2017. “Skills of the future: How to thrive in the complex new world.” <https://futuref.org/futureskills>. 2023.10.24.